

**МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ТУСГААР
ТОГТНОЛЫН ТЭМЦЭЛ
(1755-1758)**

Н. Ишжамц

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Төв Азийн улс орнууд, түүний дотор мөн Монгол орон бол эрт дээр үеэс тусгаар тогтнон бие даасан орон билээ. Нүүдэлчин улс түмэн нь өвөрмөц амьдрал ахуйтай ертөнц байв. Нүүдэлчид өөрийн гэсэн төр улс, хууль цааз гадаад харилцааны тогтолцоо цэргийн байгуулалттай байсан бөгөөд нилээд хөгжсөн нүүдэл иргэншлийн соёлыг бүтээж байсан байна. Энэ бүхний учир нүүдэлчин улс түмнүүд тусгаар тогтнолоо бэхжүүлж, бүрэн эрхт байдлыг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж сурсан байв.

Гэтэл орчин үеийн хятадын түүх судлалд Төв Ази, ялангуяа Монгол орныг угаасаа Дундад улсын салшгүй хэсэг байсан мэт дүрсэлж байна. Мөн Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийг гурав дахь орны хатгалгаар гарсан, «хятадын эсрэг феодал ноёдын хөдөлгөөн» гэж үзээд тэр тэмцлийн бүх удирдагчид Монголын төрийн дэвшилт зүтгэлтэн нарыг «урван тэрслэгчид» гэж бичдэг болсон юм. Гэвч энэ бүхэн нь үнэн байдалд огтхон ч нийцэхгүй .

Монголын төрийн түүх нь М.Э Ө Ш--М Э I зууны үед оршин тогтнож байсан Хүннү гүрэн, I-IV зууны үед байсан Сяньби улсын үеэс эхэлсэн олон зуун жилийн уламжлалтай.

XIII зууны үед Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь хятадын феодал, ноёдын түрэмгийллийн эсрэг монгол орны тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Гэвч XIII-XIV зууны Монголын феодалын байлдан дагуулал нь эзлэгдсэн орнуудад төдийгүй, өөрийн оронд ч ихээхэн хор хөнөөл уч- руулсан юм.

Монголын феодалын эзэнт гүрэн мөхсөний дараа XV-XVII зууны үед феодалын тархай бутархай байдал зонхилж, улс орон эцэстээ Ар, Өвөр, Баруун Монголын гурван хаант улс буюу ханлиг болж хуваагдсан нь түүний эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадлыг эрс доройтуулсан юм. Монголын ард түмэн ноёлогч ангийн зарим төлөөлөгчид хэдийгээр эх оронч баатарлаг тэмцэл хийсэн боловч 1634-1636 оны үед Өвөр Монголын Цахарын ханлиг нь Манжийн түрэмгийлэгчдийн ноёрхолд орсон юм. Цэрэг феодалын Манж улс удалгүй феодалын Хятадын Мин улсыг эзэлж, нийслэлээ Бээжинд шилжүүлсэн нь монголын эсрэг хятадын ноёрхогч ангийн хэзээ язааны шунахай бодлогыг идэвхжүүлэх нөх- цөлийг бүрдүүлсэн юм. Түүний үр хөврөл нь Ар Монголын Халхын ханлиг, Баруун Монголын Зүүнгарын хаант улсын эсрэг манжийн төрийн туйлын түрэмгий бодлого болсон билээ.

1691 онд Манж Чин улсын засгийн газар нь Халхын феодал ноёдод харгис эрхшээлээ тулган хүлээлгэж, 1755 онд Зүүн гарын ноёдын зөрчил маргаанаар дашрамдуулан Баруун Монголд хоёр замын их цэрэг түрэн оруулсан юм. Манж цэргийн жанжин нар Зүүнгарын зарим ноёдын урвалт, өөрийн мэдэлд байсан Монгол, хятад цэргийн хүчийг ашиглан Баруун Монголын ихээхэн хэсгийг байлдан эзэлж, хааныг нь хүртэл олзлон авчээ. Ингээд бүх Монгол бүрмөсөн Манжид эзлэгдсэн мэт болжээ. Гэтэл хэргийн байдал тийм биш болоод удал төдөлгүй Манж нарын гол нь гонсойход хүрчээ.

Манжийн байлдан дагуулал нь хятад түүхчдийн номлодог ёсоор бол Хятадын бүрэлдхүүн хэсгүүдийн нэгдлийг сэргээн, Монголд ч гэсэн дэвшилттэй нөлөө үзүүлээд Монголчууд бараг сайн дураараа Чин улсад дагаар орж захирагдсан мэт үзэх ёстой ажээ. Гэтэл Зүүнгарт Манжийн цэрэг цөмрөн орсны дараахан Монгол даяар Манж, Хятадын дарлалыг эсэргүүцсэн тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл өрнөсөн юм. Эхлээд Баруун Монголд, дараа нь Ар Монголд бослого гарч, Өвөр Монголд ч гэсэн янз бүрийн эсэргүүцэл тэмцэл дэгдсэн байна. Энэ бүхэн нь санамсаргүй хэрэг биш байв.

Монгол, манж, хятад түүхийн сурвалжууд, ялангуяа манай улсын архивын баримтаас үзвэл Монголын малчин ардууд Манжийн ноёрхол, түүнтэй цуг тус оронд нэвтрэн дэлгэрч байсан хятадын худалдаа, мөнгө хүүллийн капиталын талхидлыг анхнаасаа эрс хатуу эсэргүүцэн тэмцэж байжээ. Манж, хятадын талхидал Монгол ноёдын эрх ашигт ч гэсэн хохирол учруулж байсан учир тэдний олонхи нь түүнийг дотроо бас таалахгүй байжээ. Тус оронд зонхилж байсан бүддийн шашин, хүрээ хийдийн нөлөө бүхий хэсгийн дунд хүртэл янз бүрийн дургүйцэл байж, ялангуяа доорд шатны жирийн лам хуврагууд харийн дарлалд багагүй зэвүүцэж байв.

Манжийн дарлалыг эсэргүүцсэн Монголын ард түмний XVIII зууны дунд үеийн зэвсэгт тэмцлийн талаар 1960-аад оны эхнээ БНМАУ-д зарим шинжилгээний бүтээл, архивын материалын эмхэтгэл сэлт хэвлэгдэн гарсны дараа Монгол, Зөвлөлтийн болон бусад орны эрдэмтдийн бичсэн зохиол, номын бүлэг зүйлс болон өгүүллүүд нийтлэгдсэн буй. Тэдгээр бүтээл нь бидний санаа дүгнэлтийг нотлон, нарийсган гүнзгийрүүлээд, нэлээд асуудлыг бас шинээр тавьж шийдвэрлэх зэргээр түүхийн шинжлэх ухааныг улам баяжуулж өглөө.

Энэ бүх шинжилгээний үр дүнгээс үзэхэд 1755 оны хавар Монгол дахь Чин улсын цэрэг, өрнө харуулын алба хэтэрхий хүндэрч, улмаар Ойрад-Зүүн гарын эсрэг аян дайн эхэлмэгц тус орон даяар Манжийн цэргийн албанаас зугатах, Чин улсад албан татвар, хятад худалдаачдад өр төлөхөөс зайлсхийх явдал энд тэндгүй гарч иржээ. Нэн түрүү Манж түшмэд, хятад худалдаачдын эсрэг, дараа нь мөн харьд уравсан зарим монгол ноёдын эсрэг ардууд үймээн тэмцэл гаргаж байв. Харийн дарлалыг ард түмэн цаашид тэвчин эс хүлцээд, улс төрийн байдал эрс хурцдаж, зэвсэгт тэмцлийн гал дүрэлзэх нь цаг мөчийн асуудал болсон байв.

Монголын ард түмний тэрхүү зэвсэгт тэмцлийг Баруун Монголын Амарсанаа, Ар Монголын Чингүнжав, түүнчлэн мөн Өвөр Монголын Сэвдэнбалжир нарын зэрэг манжийн эсрэг, эх оронч үзэл бодол агуулсан зарим ноёд толгойлсон байна. Тэд Баруун ба Ар, Өвөр Монголд 1755 оны зун манжийн эсрэг нэгэн зэрэг бослого гаргахаар төлөвлөн тохиролцжээ. Гэтэл тэдний зорилго төлөвлөгөө илэрч, Сэвдэнбалжир манжид баригдаад Өвөр Монголд бослогыг удирдан өрнүүлэх боломжгүй болсон юм. Ар Монголд ч гэсэн бослого эхлэх явдлыг элдэв шалтгааны учир бүтэн жилээр хойшлуулахад хүрсэн юм. Гагцхүү Баруун Монголд бослого бага зэргийн сааталтайгаар бараг болзсон хугацаандаа эхэлжээ.

Анх Зүүнгарын хаан ширээний төлөө өрнөсөн феодал ноёдын өрсөлдөөний учир Чин улсаас дэмжлэг эрж очоод Манжийн жанжин нарын хамт эх орондоо харийн цэрэг удирдан буцаж ирсэн Амарсанаа чиглэл замаа дахин эрс өөрчилж, 1755 оны намар өөрийн тугийн доор шууд захирагдан явсан 300 монгол цэргийн хамт манжийн эсрэг босч, Монголын ард түмний зэвсэгт тэмцэл өрнөсөн байна. Мөн тэр үеэр зүүнгарын зайсан Дондогмаанж нарын толгойлсон бослогын цэргийн зарим ангиуд манж, хятад байлдан дагуулагчдын гол хүчийг дайран бутцохижээ. Манжийн цэргийн гурван жанжны хоёр нь амиа хорлож нэг нь тугаа хээр хаяж зугтан одсон байна. Зугтсан тэр жанжин 1756 оны эхээр сэлбэг хүч авч Амарсанаатай байлдсан боловч ялагдсан байна.

1756 оны дундуур Амарсанаа, Дондогмаанж нарын цэрэг нийлэн нэгдсэний дараа бослогын эрч хүч ихэд нэмэгдэж ирсэн юм. Гэтэл манжийн цэргийн шинэ их сэлбэг хүч довтлон ирэхэд тэд нэгдмэл байдлаа хадгалж чадсангүй. Амарсанаагийн хаанчирхах авир, тогтворгүй байдал зэргээс болж Дондогмаанж тэр хоёр дотор зуураа эвдрэн тулалдаж, Амарсанаа ялагдаад Казахийн Дунд ордны ханлигийн зүг зугтан гарчээ. Тэрхүү Дунд ордны хан Аблай нь манжийн эсрэг чиглэл баримталдаг хүн байсан учир Амарсанааг дуртайяа хүлээн авч, зохих тусламж үзүүлж дахин хөлжүүлсэн юм. Харин Дондогмаанжийн цэрэг нь Амарсанаагийн эсрэг тулалдаанд сульдаад манж нарт цохигдон хүнд хохирол үзсэн байна. Энэ бүхэн нь бослогын цаашдын өрнөлт явцад айхтар сөрөг нөлөө үзүүлсэн юм.

1756 оны сүүлчээр Галсандорж нарын зэрэг Баруун Монголын бас нэг хэсэг ноёд цэргийнхээ хамт босч, манж цэргийн томоохон хүчийг бутцохисон боловч мөн ноёдын дажин хямралаас болж, тус тусын нутаг усны зүг тархан сарнисан байна.

1757 оны хавар Амарсанаа эх нутагтаа буцаж ирээд дахин хүч хуралдуулж, манжийн эсрэг шийдвэрлэх тулалдаанд орсон байна. Тэр тулалдаан мөн оны 6-р сарын хуучдаар Зүүнгарын Шарбал нутагт эхэлжээ. Тулалдаанд тухайн цагийн байдлаар дээд зэргийн зэвсэглэл бүхий Чин улсын шилмэл түм гаруй цэргийг манжид үнэнч халхын Сайн ноён хан Цэнгүнжав, түүний дүү Цэвээнжав нар удирдан оржээ.

Амарсанаагийн цэргийн тоо 2500-гаас хэтрэхгүй байсан боловч тэд 17 хоногийн турш хүчин давуу, залихай дайсны эсрэг баатарлаг тэмцэл хийж, ана мана тулалдан, түүнд сүрхий хохирол учруулжээ. Гэвч хүчний харьцаа хэтэрхий тэнцвэргүй байсан нь эцэстээ мэдэгдэж, бослогын цэргийн гол хүчин арга буюу цохигдсон байна. Амарсанаа Оросын зүг зайлан гараад өвчилж нас барсан юм.

Манж нар бослогын цэргийн бусад багуудын эсэргүүцэл тэмцлийг дарахдаа 1757 оны дэд хагас, 1758 оны туршид Баруун Монголын хүн амыг эр эм, нялхас өтгөс ялгаагүй бүгдийг алан хядаж байв. Тэд Зүүнгар нутгийн уул ус, ой хөвч, хээр тал болон цөл говьд ойрадуудыг энд тэндгүй эрэн хайж зэрлэг араатан намнах адил агнаж устган байв. Үүний улмаас Зүүнгарын хаант улсын 600 мянга гаруй монгол хүн амын тавны дөрвөн хувийг хядаж устгасан байна. Үлдсэн цөөн хэсэг нь Казах, Халимаг, Сибирийн зүг зугтан гарч амь хоргодсон байна. Нэгэн үе хүчирхэг мандаж байсан Зүүн гарын хаант улсын дэвсгэр нутаг бүрмөсөн эзгүйрэн хоосроод Чин улс манж, солон, цахар цэрэг оруулж сахиулсан үзэгдэнэ.

Баруун Монголын Зүүнгарын хаант улсыг байлдан эзлээд манж нарын үйлдсэн бүх нийтийн алан хядлага нь дэлхий нийтийн түүхэнд ажиглагдсан хайр найргүй анхны хүйс тэмтэрлэг, аймаглан устгах бузар булай явдлын нэг даруй мөн байв.

1756 оны зун дээр дурьдсанчлан Халхын засагт хан аймгийн ноён, хотгойдын шадар ван Чингүнжав Ар Монголд Манж, хятадын эсрэг бослого гаргажээ. Түүний ууган хамтран зүтгэгч зоригжуулагч эчнээ зөвлөгч нь Монгол хаадын удам угсааны нөлөө бүхий сурвалжит язгууртан, халхын Түшээт ханы ойр төрөл, II богдын төрсөн ах Эринчиндорж байжээ. Гэвч тэр сурвалжтан Манжид баригдаж, балмад хэрцгий цаазлагдан амь үрэгджээ. Манж нар тийнхүү монголчуудыг айлган сүрдүүлэх гэсэн нь харин эрс эсрэг үр дагавартай учирсан байна.

1756 оны 6-р сард Чингүнжав өөрийн тугийн доорхи 800 монгол цэргийн хамт Зүүнгар дахь Чин улсын цэргийн албыг хаяж, Ар Монгол, Хотгойд нутагтаа буцаж иржээ. Тэрээр халхын ноёд, цэрэг, ардын зүг хандаж тусгай уриалга гаргасныхаа дотор дурьдсан нь: «Манжийн хаан өөлд монголчуудтай дайныг нүрж, цэргийн хэрэглэлд халхчуудыг зовоон, мал зүйлийг дайчилж, зүйл зүйлээр зүдрүүлж, бас Чингисийн угсааны ван Эринчиндоржийг яллаж, хилсээр үхүүлсэн зэрэг учрыг гаргаж даруй хүчийг хамтатган, Манжийн хаанаас салбал зохино» гэжээ.

Чингүнжавын дараа Халхын дөрвөн аймгийн гурвынх нь хангууд, тухайлбал Түшээт хан Ямпилдорж, Засагт хан Балдир, Сэцэн хан Манибадар, жич чин ван Дэчинжав, гүн Дамиран нарын зэрэг нөлөө бүхий ноёд тус тусын харьяат ардын хамт Манжийн цэргийн албыг хаяж нутагтаа буцаж иржээ. Гэвч тэд цаашдаа бослогын үйл хэрэгт асар идэвхтэй оролцсонгүй. Халхын улс төр, засаг захиргааны болон шашны төв Их хүрээнд байнгын өргөө бүхий залуухан монгол II богд хүртэл ахыг нь манж нар цаазаар авсанд илээр ундууцаж, босогчидтой нийлнэ гэж Манжид шууд заналхийж эхэлсэн байна. Яггүй айж цочсон манжийн засаг захиргаа нь түүнийг бараа бологчдынх нь хамт нэн даруй гэрийн хүндлэлт хорионд хашин авч, бусдаас бүрмөсөн таслан хөндийрүүлээд түүний нэрийн өмнөөс Чингүнжав тэргүүтэй босогчдын эсрэг эсэн бусын хуурамч уриа лоозон гарган тарааж байв.

Гэсэн ч 1756 оны зун, намрын үест Халхын дөрвөн аймагт газар сайгүй хэдэн арваас хэдэн зуун хүнтэй бослогын цэргийн анги багууд байгуулагдаж, тус орон дахь чин улсын засаг захиргааны байгууллагуудыг бутниргэж, өртөө, харуулуудыг дайран, манж цэргийн ангиудыг довтлон цохиж байв. Босогчдын багууд нь манж нарын эзэгнэж байсан хот суурин, бэхлэлт боомтуудыг шийдвэртэй дайран довтолж байв. 1756 оны зун босогчдын нэгэн баг Их хүрээг дайрч, 300 орчим хүнтэй өөр нэг баг умард хилийн Хиагт хотод довтлон орж, манж түшмэд, хятад худалдаачдыг түйвэргэсэн байна. Халх даяар, ялангуяа томоохон хятад пүү- сүүд төвлөрсөн Түшээт хан аймгийн нутагт босогчид хятад худалдаачин, мөнгө хүүлэгчдийг олонтаа довтолж, эд хөрөнгө, мал сүргийг нь үг дуугүй хураан авч байв. Архивын баримт бичгүүдийн дотор энэ тэр хятад пүүсэнд «Монгол хулгайч хэд хэдэн зуу илүү хүн ирж, эд бараа, малыг цөм дээрэмдэн булаан аваачив» гэж тухайн үед хятадуудын мэдүүлж байсан мэдээ сэлт цөөнгүй дайралддаг. Түүнээс гадна, босогчид онцгой балмад Монгол ноёд түшмэдийг, ялангуяа харийн булаан эзлэгчдэд урьд адил үйлчлэн зүтгэсээр үлдсэн этгээдүүдийг замаасаа шууд зайлуулж байв.

Чингүнжав халхын нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн нарыг бослогын үйл хэрэгт татан оруулах талаар эрчимтэй ажил зохиож байжээ. Нэгэн талаар II богдод элч зарж, нөгөө талаар тус орны хамгийн, томоохон сайд түшмэдийг Их хүрээнд чуулган нийлж, эх орныхоо тусгаар тогтнолыг сэргээн мандуулах тухай асуудал хэлэлцэе гэж урьж байв. Гэвч манж нар чуулганыг нийлүүлэлгүй тасалдуулах арга явууллага үйлдэж, Чингүн-

жавыг Халхын төв ба өрнө, дорнын аймаг, хошуудаас тусгаарлан хөндийрүүлж амжсан байна.

Манж нар Ар Монгол дахь бослого хөдөлгөөнийг дарахын тул мөн л Зүүнгарын ард түмний тэмцлийг цус урсган даралцсан Халхын Сайн ноён хан Цэнгүнжавыг тохоон томилж, нэмэгдэл их хэмжээний цэрэг, зэвсэг хүнс хэрэглэгдэхүүн гаргаж өгчээ. Хүч тэнцүүргүй хүнд тулалдаануудын үеэр Чингүнжав дайсны давуу хүчинд ноцтой цохилт өгч байсан боловч ялж хараахан чадсангүй. 1756 оны эцэст Чингүнжав бас Оросын зүг ухран одсон боловч дараачийн шинэ оны эхээр дайсанд баригджээ. Манж нар Чингүнжав, түүний гэр бүл, үр ач нарыг маш хэрцгий тамлан цаазалж удам угсаагаар нь устгахыг зорьсон байна. Чингүнжавын нас барсны дараа Ар Монголд бослого 1758 оны дэд хагас хүртэл үргэлжлээд Чин улсын цэрэг, урвагч зарим ноёд түшмэдийн эвсэл хүчинд цохигдож дарагдсан байна.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг тийнхүү дарахдаа Манж байлдан дагуулагчид нь Халхад Монгол богд байх явдлыг хүртэл аюултай гэж үзээд II богдыг сэм хорлон алж, хойшид Төвдөөс түүний дүрийг тодруулах болгосон байна. Мөн түүнчлэн Чин улсын цэргийн албыг босогчидтой цуг нэгэн зэрэг хаяж, тусгаар тогтнолын тэмцэлд талархах байдал гаргасан Халхын дөрвөн аймгийн гурван ханы амь насыг далдуур бүрэлгэжээ. Халхын Сайн ноён хан Цэнгүнжав, түүний дүү Цэвээнжав нарыг бослого дарсных нь хувьд ихээхэн дуулиантайгаар хэдэн зэрэг нэмж, өндөр хишиг хүртээгээд, цаашид хэт их хүч нөлөөтэй болохоос нь бас болгоомжилж, үе улиран үр угсаагаараа Бээжинд залран суух болгож, цэрэг, эх орон, ойр дотнын хань нөхдөөс нь таслан холдуулах арга хэмжээ авчээ. Тэдний үр ач нар нь маш өндөр зэрэг хэргэм, эрх тушаалтай боловч онцын гойд хүч нөлөөгүй Монгол Наянт вангийн өвөг дээдэс, зэрэмдэг манж, хятад маягийн хүмүүс болж, Манжийн хааны ордонд цаг мөчийг цэнгэн өнгөрөөж байв.

Дээр дурьдсан бүх зүйлээс үзэхэд манжийн ноёрхлыг эсэргүүцсэн Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн гол хөдөлгөгч хүч нь хөдөлмөрчин малчин ардууд байсан бөгөөд зарим феодал ноёд түүнд нийлэн нэгдэж, түүнийг толгойлж удирдсан байна. Бослогын зорилго нь харийн байлдан дагуулагчдыг хөөн зайлуулж, эх орныхоо төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг сэргээх явдал байв.

Ард түмний бослого тэмцэл дарагдсан гол шалтгаан нь хөдөлгөөн нэгдмэл удирдлагагүй байсан, Бээжингийн зүгээс залихай бодлого явуулж, феодал ноёд дотор зуураа хэт хямарч босогчдын нэгдэл нягтралыг алдагдуулсан, гадаадаас тусламж дэмжлэг олох боломж туйлын хязгаарлагдмал байсан зэрэгт оршино

XVII зууны үеэс эхлэн Манжийн түрэмгийлэлтэй уялдаж Монголчууд Оросын Зүг хандан эргэж, умард хөршөөсөө тусламж дэмжлэг эрэх болсон нь түүхэн утга учир бүхий бодит үйл явдал юм. Орос улс Монголтой хэдийгээр найрсаг харилцаатай, талархан ханддаг байсан боловч дотоод, гадаад зарим нөхцөл байдлын учир Монголчуудад тухайн үедээ тодорхой дэмжлэг үзүүлэх боломжгүй байжээ.

Амарсанаа, Чингүнжав нарын бослого бол Манжийн эсрэг Монголын ард түмний XVII-XVIII зууны чөлөөлөх тэмцлийн дээд цэг мөн байв. Тэр тэмцэл энэ удаа зорилгоо биелүүлж чадаагүй боловч тусгаар тогтнол, эрх чөлөөг эрмэлзсэн ардын зориг өчүүхэн төдий ч шантраагүй билээ. 1911-1912 онд өрнөсөн Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь манжийн ноёрхлыг түлхэн унагаж, үндэсний төрийг шашин төрийг хослон баригч Богд хаант улсын хэлбэрээр мэдээж

хэмжээнд сэргээсэн юм. Дэвсгэр нутаг, төрийн ёсны хувьд Манжийн өвийг залгамжлах санаархал агуулсан Хятадын эзэн эрхийг богд хаант Монгол улсын засгийн газар хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж байв.

Гэвч зөвхөн Октябрийн хувьсгалын дараах олон улсын харилцааны шинэ нөхцөлд л Монгол оронд үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцэл бүрэн амжилт олох боломж гарсан юм. Үнэхээр Монголчуудын эрх чөлөөний тэмцлийн дараагийн шатнаа 1921 оны ардын хувьсгалын ялалтын ачаар Монголын ард түмэн жинхэнэ бие даасан байдал, эрх чөлөөг олсон билээ.

Тэр цагаас эхлэн БНМАУ-ын төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал нь социализм, орчин үеийн иргэншил хүнлэг энэрэнгүй ёсны үндсэн дээр найдвартай бэхжин, тус орны эдийн засаг, соёл гуйвалтгүй хөгжиж, ард түмний амьдрал байдал жилээс жилд дэвжин дээшилсээр ирлээ.

БОРЬБА МОНГОЛЬСКОГО НАРОДА ЗА НЕЗАВИСИМОСТЬ

(1755-1758 гг)

(р е з ю м е)

Китайская историография, придерживаясь антинаучной маоистской концепции явно пытается отстоять вопреки общепризнанным историческим фактам, тенденциозное утверждение будто Монголия являлась исконной частью Китая и маньчжурское завоевание явилось для нее благом, а национально-освободительное движение монголов, носило реакционный характер.

Однако, на самом деле Монголия с самого начала была независимой страной со своей государственно-политической, юридической, и военной системой. Но XVII в. в силу феодальной раздробленности и предательства реакционной части феодалов она попадает под маньчжурское иго.

Монгольский народ неоднократно восставал против чужеземных захватчиков, борясь за восстановление суверенитета страны. Одной из ярких страниц освободительной борьбы монгольского народа явилась антиманьчжурская вооруженная борьба монголов в 1755-1758 гг, или восстание Амурсаны и Чингунжава, которое охватывало Халху и Западную Монголию.

Главной движущей силой восстания был трудовой народ-рядовые скотоводы. Наряду с аратством в нем участвовали также некоторые представители имущих классов и духовенства.

Восстание Амурсаны и Чингунжава явилось кульминацией освободительной борьбы монгольского народа XVII-XVIII вв.

Маньчжурское иго в Монголии было свергнуто в 1911 г на следующем этапе освободительной борьбы монгольского народа. Но настоящую свободу монголам принесла лишь Народная революция 1921 г.